


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД
ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ
НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО
ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО
БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ГАДААД ХУДАЛДАА (2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт:
Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 9 сарын дүнгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **20,390.9** сая ам.долларт хүрч

2023 оны мөн үеэс 2,339.3 сая ам.доллар буюу 13.0 хувиар өсжээ. Экспортын дүн импортын дүнгээс **3,174.4** сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

Үзүүлэлт	эхний 9 сар				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	11,510.7	15,280.6	18,051.7	20,390.9	2,339.3	13.0
-Экспорт	6,383.5	8,924.2	11,296.2	11,782.7	486.5	4.3
-Импорт	5,127.2	6,356.4	6,755.5	8,608.3	1,852.8	27.4
Тэнцэл	1,256.3	2,567.8	4,540.7	3,174.4	-1,366.4	-30.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **3,174.4** сая ам.долларын ашигтай гарсан байна.

Импорт: 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр импорт **8,608.3** сая ам.долларт хүрч, 2023 оны мөн үетэй харьцуулахад 1,852.8 сая ам.доллар буюу 27.4 хувиар өссөн байна

Экспорт: Экспортын худалдаа 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр **11,782.7** сая ам.долларт хүрч, 2023 оны мөн үетэй харьцуулахад 486.5 сая ам.доллар буюу 4.3 хувиар өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **87.4** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **12.6** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

оноос 563.9 сая ам.доллар буюу 5.8 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **1,487.9** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 77.4 сая ам.доллар буюу 4.9 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **10,294.8** сая ам.долларт хүрч, өмнөх

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 9 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	5,384.0	7,602.8	9,730.8	10,294.8	563.9	5.8	87.4
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,020.8	1,321.4	1,565.3	1,487.9	-77.4	-4.9	12.6
Нийт экспорт	6,404.7	8,924.2	11,296.2	11,782.7	486.5	4.3	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс

ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын **93.8** хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 9 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,151.3	1,186.4	35.1	3.0
Нүүрс	сая.тн	46.8	59.1	12.3	26.3
Төмрийн хүдэр	сая.тн	4.2	5.5	1.2	28.8
Цайрын баяжмал	мян.тн	128.8	91.9	-36.9	-28.7
Алт	тн	9.0	9.0	0.0	0.3
Боловсруулаагүй нефть	сая.баррель	3.6	3.1	-0.5	-12.9
Катодын зэс	мян.тн	9.1	9.2	0.1	1.0
Жоншны баяжмал	мян.тн	733.5	918.9	185.4	25.3
Адууны мах	мян.тн	23.9	14.1	-9.8	-41.2
Өлөн гэдэс	тн	379.8	454.9	75.1	19.8

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	10.0	26.5	16.5	165.1
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	306.3	246.2	-60.1	-19.6
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	37.4	0.4	-37.0	-98.9
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	42.7	38.4	-4.4	-10.2
Ямааны самнасан ноолуур	тн	689.4	471.9	-217.5	-31.6
Ямааны угаасан ноолуур	тн	4,836.2	4,678.2	-158.0	-3.3
Самнаагүй хонины ноос	мян.тн	9.7	5.6	-4.0	-41.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	эхний 9 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	1,999.8	2,264.4	264.6	13.2	19.2
Нүүрс	6,417.7	6,653.1	235.3	3.7	56.5
Төмрийн хүдэр	323.6	446.7	123.1	38.0	3.8
Цайрын баяжмал	191.6	131.9	-59.8	-31.2	1.1
Алт	560.8	670.5	109.7	19.6	5.7
Боловсруулаагүй нефть	271.0	248.9	-22.1	-8.2	2.1
Катодын зэс	75.6	81.1	5.5	7.2	0.7
Жоншны баяжмал	185.5	214.8	29.4	15.8	1.8
Адууны мах	92.0	49.8	-42.1	-45.8	0.4
Өлөн гэдэс	7.1	9.0	1.9	26.6	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.6	0.5	-0.1	-16.2	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.8	0.7	-0.1	-12.6	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.6	0.0	-0.6	-99.3	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	1.1	1.0	-0.1	-9.0	0.0
Ямааны самнасан ноолуур	66.2	46.4	-19.8	-30.0	0.4
Ямааны угаасан ноолуур	235.8	252.0	16.2	6.9	2.1
Самнаагүй хонины ноос	10.1	6.1	-4.0	-39.4	0.1
Нийт экспортод эзлэх хувь	88.6	94.0	5.4	6.1	94.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 5. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

/ам.доллар/

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 9 сар		Өөрчлөлт	
		2023	2024	Дүн	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	137.0	112.5	-24.5	-17.9
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,737.0	1,908.7	171.7	9.9
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	76.3	81.8	5.5	7.2
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,487.8	1,434.9	-52.9	-3.6
Алт	кг/ам.дол	62,483.7	74,495.4	12,011.6	19.2

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 563.9 сая ам.доллар буюу 5.8 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1. Нүүрс: 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 59.1 сая тонн нүүрс экспортолж, 6,653.1 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 12.3 сая тонноор өсөж, экспортын орлого мөн 235.3 сая ам.доллараар буюу 3.7 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 137.0 ам.доллараас 112.5 ам.доллар хүртэл 17.9 хувиар буурсан байна. Нүүрсний зах зээлийн үнэ буурсан боловч биет хэмжээний өсөлт нь экспортын орлого өсөхөд нөлөөлсөн байна. Нүүрсийг 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.

2.Зэсийн баяжмал: 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 13.2 хувь буюу 264.6 сая ам.доллараар өсөж, 2,264.4 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 1,186.4 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувь буюу 35.1 мянган тонноор өсжээ. Нэг тонн зэсийн баяжмалын зах зээлийн үнэ 1,908.7 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 9.9 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалын 100.0 хувийг БНХАУ руу экспортолсон байна.

3.Алт: 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр алтны экспортын биет хэмжээ 9.0 тоннд хүрч, 670.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Алтны экспортын биет хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад маш бага өсөлттэй (25.8 кг) байсан бөгөөд алтны үнийн өсөлт нь экспортын орлого өсөхөд нөлөөлсөн. Нэг килограмм алтны экспортын зах зээлийн дундаж үнэ 74,495.4 ам.долларт хүрч 19.2 хувиар өссөн байна. Алтны 77.5 хувийг Швейцар, 22.1 хувийг АНУ, 0.3 хувийг Сингапур руу тус тус экспортолсон байна.

4.Төмрийн хүдэр: 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 5.5 сая тоннд хүрч, 446.7 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 38.0 хувь буюу 123.1 сая ам.доллараар өсөхөд биет хэмжээ 28.8 хувь буюу 1.2 сая тонноор өссөн нь нөлөөлсөн байна. Нэг тонн төмрийн хүдрийн экспортын зах зээлийн дундаж үнэ 81.8 ам.долларт хүрч 7.2 хувиар өссөн байна. Төмрийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

5.Нефть: 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр боловсруулаагүй нефтийн экспортын биет хэмжээ 3.1 сая баррельд хүрч, 248.9 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Боловсруулаагүй нефтийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 8.2 хувь буюу 22.1 сая ам.доллараар буурахад биет хэмжээ 12.9 хувь буюу 0.5 сая баррелиар буурсан нь нөлөөлжээ. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **21.3** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **78.7** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,835.2** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 265.0 сая ам.доллараар буюу 16.9 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **6,773.1** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1,587.8 сая ам.доллар буюу 30.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 9 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	883.4	1,404.8	1,570.1	1,835.2	265.0	16.9	21.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	4,243.2	4,951.6	5,185.3	6,773.1	1,587.8	30.6	78.7
Нийт импорт	5,126.6	6,356.4	6,755.5	8,608.3	1,852.8	27.4	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 21.3 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 21.8 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 20.4 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 7.2 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.9 хувь химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 5.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	эхний 9 сар		Өөрчлөлт		Бүтэц (хувиар)
		2023	2024	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	106.7	106.7	0.1	0.1	1.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	107.6	154.0	46.4	43.1	1.8
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	25.8	30.4	4.6	17.8	0.4
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	478.5	620.8	142.3	29.7	7.2
5	Эрдэс бүтээгдэхүүн	1,570.1	1,835.2	265.0	16.9	21.3
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	368.6	453.7	85.1	23.1	5.3
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	263.8	295.8	32.0	12.1	3.4
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	7.3	7.4	0.0	0.4	0.1
9	Мод, модон эдлэл	58.0	84.1	26.1	44.9	1.0
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	58.0	63.8	5.8	10.0	0.7
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	109.9	105.1	-4.8	-4.3	1.2
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	26.8	29.4	2.6	9.6	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	170.6	200.5	29.9	17.5	2.3
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	4.0	4.2	0.2	5.4	0.0
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	658.4	765.9	107.4	16.3	8.9
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	1,291.5	1,754.7	463.1	35.9	20.4
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	1,239.5	1,874.2	634.7	51.2	21.8
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	95.1	104.7	9.7	10.2	1.2
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	112.8	114.7	1.9	1.7	1.3
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.1	0.1	0.0	-12.3	0.0
21	Бусад	2.4	3.1	0.7	29.1	0.0
	ДҮН	6,755.5	8,608.3	1,852.8	27.4	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2024 оны эхний 9 сард нийт 4,879.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **4,935.0** тэрбум төгрөгийг төвлөрүүлж гүйцэтгэл **101.1** хувьтай байна.

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 1,067.8 тэрбум төгрөгөөр буюу 27.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023.09		2024.09		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	гүйц.	төлөв.	гүйц.	зөрүү	хувь	зөрүү	хувь	
Нийт орлого	3,867.2	4,879.5	4,935.0	1,067.8	27.6	55.5	1.1	
Гаалийн албан татвар	1,062.5	1,391.3	1,317.3	254.8	24.0	-74.0	-5.3	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,297.6	2,940.2	2,886.8	589.2	25.6	-53.4	-1.8	
Архи, дарсны онцгой албан татвар	25.8	37.4	41.1	15.3	59.3	3.7	9.9	
Тамхины онцгой албан татвар	107.5	112.1	108.4	0.9	0.8	-3.7	-3.3	
Шар айрагны онцгой албан татвар	6.1	7.5	9.2	3.1	50.8	1.7	22.7	
Суудлын автомашины онцгой албан татвар	231.2	246.7	437.0	205.8	89.0	190.3	77.1	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	11.4	15	2.8	-8.6	-75.4	-12.2	-81.3	
Автобензин, дизель түлшний албан татвар	16.5	20.9	19	2.5	15.2	-1.9	-9.1	
Татварын Дүн	3,758.6	4,771.1	4,821.6	1,063.0	28.3	50.5	1.1	
Хураамж	87.6	97.2	104.1	16.5	18.8	6.9	7.1	
Өөрийн орлого	21.0	11.2	9.3	-11.7	-55.7	-1.9	-17.0	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс **1,067.8** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 589.2 тэрбум төгрөг;
- Гаалийн албан татвар 254.8 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 205.8 тэрбум төгрөг;
- Хураамж 16.5 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 15.3 тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар 3.1 тэрбум төгрөг;
- Автобензин, дизель түлшний албан татвар 2.5 тэрбум;
- Тамхины онцгой албан татвар 0.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Харин Автобензин, дизель түлшний онцгой албан татвар 8.6 тэрбум төгрөг, өөрийн орлого 11.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тав. Татварын чөлөөлөлт

2024 оны эхний 9 сард нийт импортод татвартай импорт **93.9** хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ **6.1** хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 5,565.4 тэрбум төгрөгөөр буюу 25.6 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт 236.6 тэрбум төгрөгөөр буюу 15.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	эхний 9 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Татвартай импорт	21,772.9	27,338.3	5,565.4	25.6	93.9
Татвараас чөлөөлөгдсөн импорт	1,531.8	1,768.4	236.6	15.4	6.1
Нийт импорт	23,304.7	29,106.7	5,802.0	24.9	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Татвараас чөлөөлөгдсөн импортын **1,768.4** тэрбум төгрөгийн бараанд 2024 оны эхний 9 сард ногдуулвал зохих **258.5** тэрбум төгрөгийн татвар холбогдох хууль тогтоомжийн дагуу татвараас чөлөөлөгдсөн байна.

Хүснэгт 9. Татварын чөлөөлөлтийн бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Үнийн дүн, мян.төг	ДҮН
Бусад	326.4	45.3
Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	449.5	69.7
Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	237.5	37.0
Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	300.9	46.3
Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	146.1	23.3
Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	37.9	5.0
ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	198.6	20.9
Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	71.5	11.1
Нийт дүн	1,768.4	258.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зургаа. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлтэд нөлөөлсөн хүчин зүйлс

Гаалийн байгууллага нь улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийг зөв, оновчтой зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч цаг үеийн шаардлагатай УИХ, Засгийн газраас баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татварын хойшлуулалт, чөлөөлөлт, хөнгөлөлтөөр 373.2 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнд:

Тариф хувь хэмжээний бууралт **5.5** тэрбум төгрөг + татварын чөлөөлөлт **258.5** төгрөг + ханшийн нөлөөллөөр **100.5** тэрбум төгрөг + Татварын хойшлуулалт **38.7** тэрбум төгрөг=Нийт **403.2** тэрбум төгрөг.

Хүснэгт 10. Ханшийн нөлөөлөл

/тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	эхний 9 сар		Өөрчлөлт	
		2023	2024	Дүн	Хувь
1	Татвартай импорт /сая ам. доллар/	6,727.9	8,619.0	1,891.1	28.1
2	Татвартай импорт/тэрбум төгрөг/	23,304.7	29,106.7	5,801.9	24.9
3	Гаалийн албан татвар болон Нэмэгдсэн өртгийн албан татвар /тэрбум төгрөг/	3,360.1	4,204.1	844.0	25.1
4	Дундаж ханш /төгрөг/	3,463.9	3,377.0	-86.8	-2.5
5	2023 оны эхний 8 сарын дундаж ханшаар тооцсон импорт / тэрбум төгрөг/	23,304.7	29,855.3	6,550.5	28.1
6	2023 оны эхний 8 сарын дундаж ханшаар тооцсон татвар /тэрбум төг/	3,360.1	4,304.6	944.5	28.1
7	Ханшны зөрүүнээс буурсан татвар /тэрбум төг/		100.5		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тарифын хөнгөлөлт, татварын чөлөөлөлт

1. Загийн газрын 2024 оны 188-р тогтоолоор батлагдсан Цементийн албан татварын хувь хэмжээг 20 хувь байсныг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд 5 хувь болгон бууруулсан тогтоолыг тарифын санд оруулж хэрэгжилтэд хяналт тавьсан. Нийт 10.8 сая ам.долларын дүн бүхий 174.4 мян.тн бүтээгдэхүүний 5.5 тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн байна.

2. 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Засгийн газрын 180 дугаар тогтоолыг тус тус үндэслэн импортын малын тэжээл болон гурил бүхий бараанд ногдуулвал зохих 5.9 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг чөлөөлжээ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС